



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/117

Зуунмод

Газар эзэмших эрхийг
баталгаажуулж, газрын хэмжээг
өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 37.1, 37.2, Монгол улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв аймгийн Зуунмод сум, Баруун Зуунмод 6-р баг, Ирээдүй хотхон, Лувсангомбын гудамж 101-А тоотод аж ахуйн зориулалтаар эзэмшиж буй 1048 м² газрын хэмжээг 4110062293 нэгж талбарын дугаартай кадастрын мэдээллийн сангийн зургийн хэмжээний дагуу 908 м² болгон өөрчилж Төв Чандмань ДЭХГ/3855562/-т дээрх зориулалтаар 60 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Төв Чандмань ДЭХГазар /Ц.Жамбалсүрэн/-т дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж, газар -эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.4. Холбогдох хууль тогтоомж, хэсэгчилсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/252 дугаар захирамжийн холбогдох хэсэг болон газар эзэмших эрхийн 0381311 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

01 000531